



# САНХҮҮ БИЗНЕСИЙН • ДЭЭД СУРГУУЛЬ •

## Бизнесийн удирдлага

Бизнесийн удирдлагын хөтөлбөрөөр зах зээлд өрсөлдөх чадвар бүхий онолын болон практик мэдлэгтэй, судалгааны арга зүйг эзэмшсэн, бие даасан бүтээлч сэтгэлгээтэй, харилцааны өндөр үр чадвартай, гадаад хэлний зохих мэдлэгтэй, бизнесийн удирдлагын мэргэжилтэн бэлтгэнэ.

Хөтөлбөрийн нэр:	Бизнесийн удирдлага
Мэргэжлийн нэр:	Бизнесийн удирдлага
Индекс:	041301
Элсэгчийн боловсролын төвшин:	Бүрэн дунд
Сургалт явуулах хэлбэр:	Өдөр
Хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх хугацаа:	Намар/Хавар
Суралцах жил:	4 жил

### Элсэлтийн Ерөнхий Шалгалт, Оноо:

- Математик (400-с дээш) + Гадаад хэл (400-с дээш)
- Математик (400-с дээш) + Нийгэм (400-с дээш)

### Хөтөлбөрөөр олгох мэдлэг:

- Дээд боловсролтой мэргэжилтний зайлшгүй мэдвэл зохих хүмүүнлэг нийгмийн ухаан, математик статистик, мэдээллийн систем суурь мэдлэг эзэмших;
- Бизнесийн удирдлагын суурь мэдлэг эзэмших;
- Бизнесийн баримт бичгийг боловсруулах, бизнесийн харилцаанд оролцох, мэргэжлийн ёс зүйг сахих;
- Мэргэжлийн англи хэлний мэдлэг, хэрэглээ;
- Тоон болон статистик шинжилгээний аргуудыг эзэмших;
- Эдийн засгийн суурь мэдлэг, микро, макро эдийн засгийн онол, нягтлан бодох бүртгэл, санхүү, маркетинг, менежмент, мэдээллийн технологи зэрэг мэргэжлийн суурь мэдлэг;

- Мэргэжлийн хүрээнд судалгаа, шинжилгээний ажлыг хийх, үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах;
- Бие хүний төлөвшилтийн болон харилцааны үр чадвар, бүтээлч сэтгэлгээ, илтгэх, мэдээллийн технологи ашиглах, өөрийгөө хөгжүүлэх, манлайлах.

#### Хөтөлбөрөөр эзэмших чадвар:

- Бизнесийн удирдлагын шийдвэр гаргах, байгууллагын нөхцөл байдлын судалгаа хийх, маркетингийн төлөвлөгөөнд тусгах стратеги болон тактикийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах, багаар ажиллах
- Мэргэжлийн онцлогийг ялган мэдэж, үйл ажиллагааны оновчтой шийдвэр гаргах, байгууллагын нөхцөл байдалд үндэслэн үйлчилгээний зөв стратегийг маркетингийн төлөвлөгөөнд тусгах
- Зах зээлийн нөхцөлийг үнэлж, тулгарч буй асуудлуудыг тодорхойлох болон шийдвэрлэх боломжит хувилбаруудыг боловсруулах, үнэлгээний хэмжүүрүүдийг тодорхойлох, оновчтой төлөвлөх, зохион байгуулах
- Байгууллагад сургалт зохион байгуулах, сургалтын үр дүнг үнэлэх, ажиллагсдын карьер төлөвлөлт хийх
- Хэрэглэгчийг таньж судлах, зан төлөвийг мөн чанарыг тогтоох, амьдралын хэв маяг болон сэтгэл зүйн хүчин зүйлийг тодорхойлох, худалдан авах шийдвэр гаргалтад үзүүлэх нөлөө, үр дүнг тайлбарлах
- Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, санхүүгийн тайланг бэлтгэх, гүйцэтгэлийг хэмжих арга зүй тодорхойлох
- Аудит ба баталгаажуулалт, удирдлагын нягтлан бодох бүртгэл ба хяналт хийх
- Мөнгө, санхүү, эдийн засгийн онол дээр тулгуурлан удирдлагын оновчтой шийдвэр гаргах
- Бизнесийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулах, удирдах, хянах, үр дүнг тайлагнах
- Бизнесийн удирдлага, зохион байгуулалт, менежмент ба стратегийн шийдвэр гаргах
- Байгууллагын хүний нөөцийн төлөвлөгөө, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр боловсруулах
- Бизнесийн ба арилжааны хууль тогтоомжийн хүрээнд байгууллагын эрх зүйн баримт бичгийг бүрдүүлж, боловсруулах, багаар ажиллах, ёс зүйтэй, өөрийгөө хөгжүүлэх

#### Мэргэжлийн хичээлүүд:

- |                                  |                                  |
|----------------------------------|----------------------------------|
| • Нягтлан бодох бүртгэлийн үндэс | • Хүний нөөцийн менежмент        |
| • Санхүүгийн бүртгэл             | • Удирдлагын шийдвэр             |
| • Санхүүгийн үндэс               | • Бизнесийн бодлого, төлөвлөлт   |
| • Санхүүгийн удирдлага           | • Инновацийн менежмент           |
| • Статистикийн үндэс             | • Бизнесийн харилцаа, ёс зүй     |
| • Эконометрикс                   | • Маркетингийн менежмент         |
| • Менежментийн үндэс             | • Худалдааны менежмент           |
| • Маркетингийн үндэс             | • Төслийн менежмент              |
| • Стратегийн менежмент           | • Эрсдэлийн удирдлага ба даатгал |
| • Үйлдвэрлэлийн менежмент        | • Мэргэжлийн англи хэл           |
| • Мэдлэгийн менежмент            |                                  |

## Төгсөөд ажиллах албан тушаал:

- Бүх салбарын дунд болон удирдах албан тушаал
- Төслийн менежер, мэргэжилтэн
- Стратеги төлөвлөлтийн мэргэжилтэн
- Байгууллагын бүх шатны менежер
- Бизнесийн зөвлөх
- Худалдааны төлөөлөгч